



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№217 /426/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.12.02

Цаг үе, үйл явдал

## БИДНИЙ БАХАРХАЛ ӨДӨРЛӨГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар улс орон даяар хэрэгжиж буй “Бидний бахархал” төслийн хүрээнд эх орны ирээдүй хойч болсон хүүхэд, залууст эх оронч үзэл хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн олон арга хэмжээг БХЯ-наас зохион байгуулж буй билээ. Энэ хүрээнд өнөөдөр “Сэргээн засалт” МСҮТ, “Эрх билэг хан нийгэмлэг” хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан “Бидний бахархал” өдөрлөгийг зохион байгууллаа.

Өдөрлөгт БХЯ-ны ТЗУГ-ын дарга хурандаа С.Ванчинхүү, ҮБХИС-ийн захирал бригадын

генерал П.Жаргалан, ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах, ЦДБЭЧ-ын дарга хурандаа Г.Золзаяа, “Эрх билэг хан нийгэмлэг” ТББ-ын тэргүүн Ц.Оюунжаргал, “Сэргээн засалт” МСҮТ-ийн захирал Б.Алтмаа болон тус сургалтын төвийн оюутнууд, “Тэмүүжин-Өрлөг” сургуулийн сонсогч нар оролцоо. Өдөрлөгийн хүрээнд “Сэргээн засалт” МСҮТ-ийн оюутнууд Монгол цэргийн музейгээр аялж монгол цэргийн аугаа түүх, соёлын биет үзмэрийг үзэж сонирхсон юм.

Үргэлжлүүлэн оюутан залуусыг ҮБХИС-ийн “Тэмүүжин-Өрлөг” сургуулийн сонсогч нар

хүндэтгэлтэйгээр угтан авч хүн нэг бүрийн зэвсэг, хэрэглээ дэлгэж танилцуулсны зэрэгцээ Хөгжлийн коллежийн сонсогч нар болон Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн офицер, ахлагч нар гардан тулааны ба бөмбөрийн үзүүлэх тоглолтоо толилуулаа.

Мөн энэ үеэр Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын уран бүтээлчид, “Тэмүүжин-Өрлөг” сургуулийн сонсогч нар, “Сэргээн засалт” МСҮТ-ийн оюутан, залууст зориулсан урлагийн тоглолтоо өргөн барьсан юм.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-19	-31

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.438	3.442
EUR	3.610	3.635
CNY	484	487
RUB	53.80	54
JPY	25.25	25.50
KRW	2.66	2.71

### ЗУРХАЙ



2022.12.02 / БААСАН ГАРАГ / БИЛГИЙН ТООЛЛЫН 9

### ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН ГАХАЙ САР ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин өчүүхэн ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 08.21-17.01

Барилдлага:

Идэр

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Сэрэхүй


## БНФУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга бригадын генерал С.Ганбямба БНФУ-аас Монгол Улсад суугаа бүрэн эрхт Элчин сайд Себастиан Сүрүн, БНХАУ-д Монгол Улсыг хавсран суугаа Батлан хамгаалахын атташе Каринь Пүжэ нарыг 12 дугаар сарын 01-ний өдөр хүлээн авч уулзав.

Уг уулзалтаар хоёр орны зэвсэглэл техник, цэргийн хамтын ажиллагаа, хамтарсан сургалт дадлагад оролцох, зохион байгуулах талаар харилцан санал солилцов.

Дэд хурандаа З.АЛТАНЗОРИГ



### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 648,731,533

Эдгэрсэн

Нийт: 626,302,650

Нас барсан

Нийт: 6,642,900

Цаг үе, үйл явдал



ЯПОН УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХЫН АТТАШЕТАЙ АЖЛЫН УУЛЗАЛТ ХИЙВ


Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга бригадын генерал С.Ганбямба Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташе дэд хурандаа Ирики Ёохэйг 12 дугаар сарын 01-ний өдөр хүлээн авч уулзлаа.

Уг уулзалтаар хоёр орны зэвсэглэл техник, цэргийн хамтын ажиллагаа, хамтарсан сургалт дадлагад оролцох, зохион байгуулах талаар харилцан санал солилцсон юм.

Дэд хурандаа З.АЛТАНЗОРИГ

Цахим шууданд

ЦАХИМ СУРГАЛТ ЯВАГДАЖ БАЙНА



Өнөөдөр буюу 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газраас ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, нэгтгэл анги, салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан бүтэц, ажилтнууд, материал хэрэгсэл хариуцсан албан тушаалтнуудтай цахим сургалт зохион байгуулж

байна.

Уг цахим сургалтаар ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийх аргачлал, зөвлөл (офицер)-ийн гүйцэтгэх эрх, үүргийн талаар, Материал хэрэгсэл хариуцсан албан тушаалтнуудад мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч, харилцан санал солилцсон сургалт болж байна.

Дэд хурандаа Б.ГЭРЭЛТ-ОД

ИНЖЕНЕРИЙН ДАЙЧИД МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШИЖ БАЙНА



Батлан хамгаалахын сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан тушаалын хүрээнд Цэргийн гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн хугацаат албаны дайчдад мэргэжил эзэмшүүлэх сургалт явагдаж байна.

Тодруулбал, Налайх дүүрэг дэх Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа Политехникийн коллежид зарим хугацаат цэргийн алба хаагчдаа 5 сарын

хугацаатай "Хүнд машин механизмын оператор", "Замчин" мэргэжлүүдээр сурган дадлагажуулж байгаа юм.

Энэхүү сургалтад хамрагдсанаар хугацаат цэргийн алба хаагчид албаа хаах хугацаандаа давхар мэргэжил эзэмших, цаашид эзэмшсэн мэргэжлээрээ эх орны бүтээн байгуулалтад гар бие оролцох өргөн боломж нээгдэж байгаа юм.

Хошууч Э.Хашцахиур (Зэвсэгт хүчний 014 дүгээр анги)

ДАЙЧИД ЭР БЯРАА ГАЙХУУЛАВ



2022 оны хоёрдугаар ээлжээр Зэвсэгт хүчний 167 дугаар ангид татагдан ирсэн дайчдын дунд хүчит 32 бөхийн барилдааныг зохион явууллаа.

Уг барилдаанд Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын харьяат Б.Доржрагчаа, Өвөрхангай аймгийн Баруун Баян-Улаан сумын харьяат Д.Нармандах, Дундговь аймгийн Сайнцагаан сумын харьяат С.Батзоригт, Дэлгэрхангай сумын харьяат Ц.Цэрэнпунцаг нар шөвгийн дөрөвт үлдсэн бол Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын харьяат байлдагч Б.Доржрагчаа түрүүлж, Өвөрхангай аймгийн Баруун Баян-Улаан сумын харьяат байлдагч Д.Нармандах үзүүрлэлээ.

Дэслэгч Б.БАТЗАЯА



СУРГАЛТ

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №29

УНШИХ, БИЧИХ ДАДЛАГА

Өмнөх хичээлээр үзсэн ХА, ХЭ гийгүүлэгч бүхий, уншихад хялбар, нэг юм уу хоёрхон үеэс бүтсэн, бичлэг дуудлага нь өнөөгийнхтэй таардаг хялбар жишээ үгсийг унших, бичих дасгал дадлага хийцгээе. Зөв уншаад, хичээнгүй бичиж, кириллээр хөрвүүлээрэй.

Дармал, бичмэл тигээр:

